


МОНГОЛЫН УЛАМЖЛАЛТ
НЭГЖҮҮД

VII анги
МАТЕМАТИК

Сурагчийн нэр:

Анги:

Бодлого 1. Хариултуудыг зөөж тохирох зургийн хажууд байрлуулаарай.



Төө



Алд



Сөөм



Давтам



Тохой



Дэпэм

16 см

18 см

71 см

160 см


32 см

100 см



Бүгд хамт бодлого
бодъё чадъя.

Бодлого 2. “Чингисийн чулууны бичиг”-т Есүнгэ ноён 335 алд газарт алдалгүй харвасан тухай тэмдэглэжээ. Хэдэн метрт алдалгүй харвасан бэ?



535 метр

536 метр

560 метр

578 метр

600 метр

Чингис хааны дүү Хавт Хасарын хүү Есүнгэ мэргэнд зориулж босгосон гэрэлт хөшөө. Боржин чулуун дээр 21 үгийг таван мөрөөр, уйгуржин монгол бичгээр ухаж сийлжээ. Хөшөөний өндөр нь 202 см, өргөн нь 74 см, зузаан нь 22 см (Чингисийн чулууны бичиг. – Чингис хааны өв. УБ., 2012. 90-р тал).

Бодлого 3. Монголчууд үхрийн элдсэн сураар сүлжиж хийсэн 9 алдын урттай бугуйлыг эмээлийнхээ хоёр бүүрэгт углах буюу биендээ мөрөвчлөн авч явдаг заншилтай. Бугуйлны уртыг метрээр илэрхийл.



Энэ хөшөөг Ойротогой Болорж наадам

Бодлого 4. 50 лан ембүү хэдэн грамм жинтэй вэ?



Ембүү нь алт мөнгийг тусгай хэвд цутган хийсэн нэг зүйл цул зоос; Монголчуудын хуучин цагийн мөнгөний нэгж

Бодлого 6. Хүндийн уламжлалт нэгжүүдийг граммаар илэрхийлж бичээрэй.

Бодлого 5. Хүндийн нэгжүүдийг зөв харгалзуулаарай.

	373 г	1 дан
	5968.2г	10 жин
	7.46 г	100 лан
	59680 г	1000 пун
	3730 г	2 цэн




Би бодлогоо бодож чадна!



Бодлого 7. 2 тэмээ 8 хонь нийлээд 18 лан мөнгөн зоос, 5 тэмээ 2 хонь нийлээд 27 лан мөнгөн зоосоор зарагдав. Тэмээний үнийг олж доорх хэсэгт бичээрэй.



Бодлого 8. Малчин 20 хургыг 3 хониор, 9 хонийг 4 бяруугаар харин 8 бярууг 3 адуугаар сольдог бол 5 адууг хэдэн хургаар солих вэ?



Бодлого 9. Наймаачин 2 морио эмээлтэй нь зарахаар болжээ. Нэг эмээл нь 120 лан мөнгөний үнэтэй, нөгөө эмээл нь 25 лан мөнгөний үнэтэй. Сайн эмээлтэй нэг дэх морь, муу эмээлтэй хоёр дахь мориноос 3 дахин их үнэтэй. Хэрэв эмээлийг сольж тохвол 2 дахь морь эмээлийн хамт нэг дэхь мориноос 2 дахин хямд болно. Хоёр морь нийлээд хэдэн лан мөнгөний үнэтэй вэ?



Би хичээлээ сайн ойлгохон тул
оюунуудыг тусам үзье.